

ХАГАС ЖИЛ, УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /МАЯГТ 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2023 оны 1-р сарын 01 - 2023 оны 6-р сарын 30
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	СҮҮ ХК, УБГД: 000219594 ҮЦК: 135-СҮҮ Утас: 7707-2222
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, Үхрийн сүүний ферм, малын тэжээлийн ургамал тариалах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	344.000.000 ширхэг
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ш.Даваалимбэ /Сүү ХК Санхүүгийн албаны дарга/

1	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав.
	Орлогын тайлан	Тайланг хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав.

2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	Хурлаар хэлэлцэж баталгаажуулсан.
---	---	-----------------------------------

3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал өмнөх оноос сайжирч, ханшийн харьцангуй тогтвортой байдал, Монгол улсын экспортын орлого нэмэгдсэнтэй холбоотой өргөн хэрэглээний бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн зэрэг гадаад хүчин зүйлс нь компанийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн. СҮҮ ХК хувьд стратегийн томоохон хөрөнгө оруулалтуудыг өнгөрөгч онд хийсний үр дүнд үйл ажиллагааны үр ашгийг сайжруулан, олон шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттайгаар нэвтрүүлж чадсан нь 2023 оны 1-р хагас жилийн ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн.
---	--	---

3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь: 28.96% Цэвэр ашгийн хувь: 12.05% Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 2023 эхний хагас: 9.87% Жилээр (Annualized) 19.74% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 2023 эхний хагас: 21.1% Жилээр (Annualized) 42.2%
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа: 1.5 Түргэн хөрвөх чадварын харьцаа: 0.56

3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөнд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Сүү ХК гадаад болон дотоод нөхцөл байдлын уялдаатайгаар импортыг орлох хүүхдэд зориулсан сүүн бүтээгдэхүүнийг шинээр хөгжүүлж эхний хагаст амжилттайгаар зах зээлд нэвтрүүлсэн. Цаашид мөн хүүхдийн болон эрүүл мэндийн чиглэлийн олон төрлийн бүтээгдэхүүнийг гаргахаар зорин ажиллаж байна. Хэрэглэгч түмний эрэлт хэрэгцээг хангах үүднээс гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг хийж ажилласан.
-----	---	---

3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НБББББичгийн дагуу бүртгэсэн.
-----	--	--

4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн ажил гүйлгээ хийгдээгүй
---	--	--

5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй
---	---	--

6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	Төлөөлөн удирдах зөвлөлтэй бөгөөд 12 гишүүнтэй, "Цалин урамшуулал", "Нэр дэвшүүлэх", "Аудит", "Эрсдэлийн удирдлага комплайнс" гэх 4 хороотой.
7	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	Компанийн шинэчлэгдсэн засаглалын кодекстэй холбоотойгоор ажлуудыг хийж дууссан бөгөөд СЗХ-д тайлагнасан.

Мэдээлэл гаргагч этгээл болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Болод
 Албан тушаал: "СҮҮ" ХК-ийн бийцэтгэх захирал
 Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ш.Даваалимбэ

Албан тушаал: Санхүүгийн албаны дарга

Гарын үсэг:



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

СҮҮ Хувьцаат Компани

СҮҮ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

www.suu.mn



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

АЛСЫН ХАРАА

Монгол сүүгээр дэлхийг ундаална

ҮНЭТ ЗҮЙЛС

Итгэл даахуйц чанар
60 жилийн туршлага
Эрүүл хүнс
Чадварлаг хамт олон
Аюулгүй орчин

ЭРХЭМ ЗОРИЛГО

Уламжлан ирсэн сүүн соёлыг орчин үеийн
хэрэглээнд нийцүүлэн түгээнэ



КОМПАНИЙН ТУХАЙ

Орчин үед сүү, сүүн бүтээгдэхүүн хүнс тэжээлийн голлох бүтээгдэхүүн болж, нэг хүн амд ноогдох сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нь улс орны үндэстний хөгжлийн түвшний чухал үзүүлэлтүүдийн нэг болжээ.

Монгол улсын ууган үйлдвэр “Сүү” ХК нь 65 дахь жилдээ нийслэлийнхээ төдийгүй хөдөө орон нутгийн хэрэглэгчиддээ зориулан экологийн цэвэр бүтээгдэхүүнээ өргөн барьж байна. Хэрэглэгчид маань бүх насны хүмүүс байдаг тул тэднийхээ онцлог, амьдралын хэв маягт нийцүүлэн бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулж, баяжуулан ажиллахыг бид чухалчилдаг.

Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээг хангахын тулд бид монгол үнээний цэвэр сүүг орчин үеийн техник технологиор боловсруулж, байгаль орчинд ээлтэй сав баглаа ашиглан үйлдвэрлэлээ явуулж байна.

Монгол улсын Хүнсний тухай хуульд “Стратегийн хүнс”-ээр монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, монгол үнээний сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг нэрлэсэн байдаг.

Ард иргэдээ чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан, монгол үнээний шимт сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангахын тулд бид хариуцлагаа ухамсарлан жилийн дөрвөн улиралд, цаг агаарын хүнд хэцүү бүхий л нөхцөлд 2500 гаруй бэлтгэн нийлүүлэгчийнхээ хотноос сүүгээ шинээр нь татан авч, мандах нартай уралдан тээвэрлэж, эрүүл аюулгүй экологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хүнс үйлдвэрлэлийн салбартаа манлайлан ажиллаж байна.

Их Монгол Улсын сүү, цагаан
идээний тусгай алба үүссэний

817 ЖИЛ



Сүү, сүүн бүтээгдэхүүн
үйлдвэрлэлийн

82 ЖИЛ



Сүү ХК-ийн

65 ЖИЛ



**ЛОГОНЫ
ХУВЬСАЛ**



1972-1985 он



1986-1995 он



1995-2000 он



2000 оноос





2023 оны 1-р хагас жилийн гүйцэтгэл

Сайн байна уу? Эрхэм хүндэт 7000 хувьцаа эзэмшигч, 4500 харилцагч, 2500 сүү бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгч та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Сүүлийн жилүүдэд СҮҮ ХК зүгээс шийдмэг томоохон хөрөнгө оруулалтуудыг хийж, 2023 оны эхний хагаст тоног төхөөрөмжүүдээ ашиглалтад бүрэн оруулснаар үндсэн бүтээгдэхүүний чанарт үсрэнгүй дэвшлийг авчирч, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулснаас гадна шинээр зах зээлд нэвтрүүлсэн хүүхдэд зориулсан сүүн бүтээгдэхүүнүүд нь хэрэглэгчдийн таашаалыг хүртсээр байна. Хамт олны нөр их зүтгэлийн үр дүнд нийт цэвэр борлуулалтын орлого өнгөрөгч оны мөн үеэс 38%, цэвэр ашиг 2.3 дахин өссөн гүйцэтгэлтэйгээр эхний хагас жилээ үдэж байна.

Манай хамт олон өнгөрөгч хагас жилд тогтвортой хөгжлийн зорилго дор сүү бэлтгэн нийлүүлэгч малчид, фермерүүд болон хоршоод руу чиглэсэн олон үйл ажиллагаа явуулсан нь үр дүнгээ өгсөөр байна. Тухайлбал 700 сая төгрөгийн дүн бүхий хүүгүй зээл, 1.3 сая тн хивэг тэжээлийг сүү бэлтгэн нийлүүлэгч малчид, фермерүүдэд үйлдвэрийн үнээр олгохоос гадна өөрийн санхүүжилтээр нэмэлт 4 хоршоодын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн, нийт сүүний хоршоодын тоог нэмэгдүүлж, Монгол улсын сүүний салбарын цаашдын өсөлт, хөгжилд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулсаар байна. Мөн малчин эмэгтэйчүүдийн нийгмийн асуудал болон боловсролыг дэмжихэд зорилгын дор 2023 оны турш борлуулагдах “Милк” сүүнийхээ орлого тутмаас 8 төгрөгийг хандивласан.

Өнгөрсөн жил Сүү ХК нь стратегийн шийдвэрийг гаргаж Макс Агро үнээний фермийг бүтцийн хувьд өөртөө нэгтгэсэн. 2023 оны эхний хагас жилд уг шийдвэр үр дүнгээ өгсөн буюу тус үнээний фермд менежментийн шинэчлэл хийн, бүтээмж сайжруулах ажил хийгдсэний үр дүнд 431 га талбайд тариалалтаа амжилтаа хийж дуусгаж, голштейн үйлдвэрийн үнээний сүүний гарцыг нэмэгдүүлсэн байна.

Түүнчлэн 2023 оны зургаадугаар сард хүүхэд багачуудын оюун ухаан, сэтгэн бодох чадварыг бага наснаас нь хөгжүүлэх, шатрын спортыг олон нийтэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Сүү” Хувьцаат Компанийн нэрэмжит өсвөрийн шатарчдын “Hi High” тэмцээнийг бид хамтран амжилттай зохион байгуулсан. Уг тэмцээн нь өргөн цар хүрээг хамарч 630 гаруй бяцхан тамирчид оюун ухаанаа уралдуулсан өгөөжтэй үйл ажиллагаа болсон тул Сүү ХК монгол оюуныг хөгжүүлэх, дэмжих их үйлсэд өөрийн тууштай хувь нэмэр болгох үүднээс цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүгээр зогсохгүй бид нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтэд чиглэсэн сайн дурын болон урт хугацааны төсөл, хөтөлбөрүүдийг санаачлан, хэрэгжүүлж байна.

Бид бүхэн цаашид сүүний салбарын хөгжлийн төлөө илүү том алсын хараатайгаар олон чанартай сүүн болон эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүдийг шинээр нэвтрүүлэхийн төлөө зорин ажиллах болно.

Гүйцэтгэх Захирал: М.БОЛОД




МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

СҮҮ Хувьцаат Компани

2023 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН


2023 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

ЦЭВЭР БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО /сая,төг/



2023 оны 1-р хагаст Сүү ХК цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38% өсөж 73.5 тэрбум төгрөгт хүрлээ.

ЦЭВЭР АШИГ /сая,төг/



Цэвэр ашгийн түвшин 8.8 тэрбумд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин өссөн үзүүлэлт юм.

Сүү ХК энэ оны эхний хагаст бүтээгдэхүүний өртгийг бууруулахад чиглэсэн олон томоохон ажлуудыг хийсний үр дүнд ашигт ажиллагаа сайжирч нийт ашгийн хувь 26% - 29% болж өссөн ба Цэвэр ашгийн хувь 7.2% - 12% болж өссөн үзүүлэлттэй байна.


2023 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Орлого үр дүн (сая.төг)	2022 Н1	2023 Н1
Борлуулалтын орлого (цэвэр)	53,351.01	73,522.24
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	39,466.30	52,228.13
Нийт ашиг	13,884.72	21,294.11
Татварын өмнөх ашиг	4,249.21	10,608.51
Тайлант үеийн цэвэр ашиг	3,851.74	8,858.18

Санхүү байдлын тайлан (сая.төг) /Хураангуй/	2022 Q4	2023 Q2
Эргэлтийн хөрөнгө	31,202.00	34,831.51
Эргэлтийн бус хөрөнгө	56,626.12	56,821.08
Нийт хөрөнгө	87,828.12	91,652.58
Богино хугацаат өр төлбөр	31,270.43	23,121.04
Урт хугацаат өр төлбөр	19,095.43	21,880.74
Нийт өр төлбөр	50,365.86	45,001.78
Эздийн өмч	37,462.26	46,650.80
Нийт өр төлбөр ба эздийн өмч	87,828.12	91,652.58


2023 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

ROA ба ROE




2023 оны 1-р хагас жилийн байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж (annualized) ROE нь 42% хүрч, нийт хөрөнгийн өгөөж (annualized) ROA нь 19% хүрлээ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ /сая,төг/



Байгууллагын үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ өмнөх оны мөн үеэс 8.8 дахин сайжирсан үзүүлэлттэй байна.

НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /Төгрөг/



НИЙТ **15.4 ТЭРБУМ**
ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ ТАРААСАН

2022 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан

“Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 08 сарын 18-ны өдрийн №16 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолоор компанийн 2022 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 4.60 /Дөрвөн төгрөг жаран мөнгө/ төгрөг буюу нийт 1,581,375,394 /Нэг тэрбум таван зуун наян нэгэн сая гурван зуун далан таван мянга гурван зуун ерэн дөрөв/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Дээрх тогтоолын дагуу 2023.02.10-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тарааж дуусгав.

2022 оны сүүлийн хагас жилд ногдол ашиг тараах тухай шийдвэр

“Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2023 оны 02 сарын 17-ны өдрийн №06 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолоор компанийн 2022 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 2,4 төгрөг /Хоёр төгрөг дөрвөн мөнгө/ буюу нийт 835,426,098 /Найман зуун гучин таван сая дөрвөн зуун хорин зургаан мянга ерэн найм/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Энэхүү шийдвэрийн дагуу 2023.05.01-2023.12.31-ний өдрийг хүртэл хугацаанд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тарааж дуусгахаар болсон.

2023 оны эхний хагас жилд ногдол ашиг тараах тухай шийдвэр

“Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2023 оны 08 сарын 16-ны өдрийн №24 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолоор компанийн 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 7.7 төгрөг /Долоон төгрөг долоон мөнгө/ буюу нийт 2,642,117,608.9 /Хоёр тэрбум зургаан зуун дөчин хоёр сая нэг зуун арван долоон мянга зургаан зуун найман төгрөг есөн мөнгө/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөр тогтоож, 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор ногдол ашгийг тарааж дуусгахаар болсон.



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

СҮҮ Хувьцаат Компани

2023 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ



Нэг хүнд хоногт
ногдох сүүний
ХЭМЖЭЭ

200 ГР

2023 оны шинэ бүтээгдэхүүн



Хүүхдэд зориулсан амтат сүү



Амтат сүү



“Амтлаг” жимстэй ааруул



SUUPER frozen yogurt



SUUPER frozen shake

БОРЛУУЛАЛТЫН ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

СҮҮ

39% ↑



ТАРАГ

20% ↑



ЦӨЦГИЙН ТОС

6X ↑



ЗАЙРМАГ

14% ↑



ААРЦАН
БҮТЭЭГДЭХҮҮН

30% ↑



Орон нутгийн зах зээл



Борлуулалтын
өсөлт **Х3**



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

Монгол сүүгээр дэлхийг ундаална



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР



- Бифидо бактери агуулдаг учраас биеийн биологийн тэнцвэрийг хадгалдаг
 - Биеийн дархлааг сэргээнэ
- Ходоод гэдэсний ашигтай нянгуудыг нэмэгдүүлж, хорыг гадагшлуулна
 - Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөний сайжруулна
 - Өтгөн хаталтын эсрэг тустай
 - Илүүдэл жинтэй тэмцэхэд ашигтай




 СҮҮ Хувьцаат Компани

**ЭРҮҮЛ
 СОНГОЛТ,
 ИРЭЭДҮЙ**

**ӨДӨР БҮР
 СҮҮПЕР**

Гүзээлзгэнэтэй - СҮҮ -
 Шоколадтай - СҮҮ -
 Кальци, D витаминтай - СҮҮ -

Natural
 Шоколадтай
 Гүзээлзгэнэтэй

200ml



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

СҮҮ Хувьцаат Компани

2023 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН ТОМООХОН ОРУУЛАЛТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ХИЙЖ ДУУСГАН АШИГЛАЛТАНД ОРУУЛАВ.

Миний Монголын сүү
үйлдвэрлэх шугам
шинэчлэгдсэнээр үйлдвэрлэл
хүчин чадал
2 дахин нэмэгдсэн.

Хүүхэдэд зориулсан
бүтээгдэхүүн үйлдвэрлэх
асептик болон DOYPACK
савалгааны шугам
суурилуулав.



Хүчин чадал



СҮҮ ХҮЛЭЭН АВАХ
ХҮЧИН ЧАДАЛ
200ТН
/ХОНОГТ/



СҮҮ ХАТААХ
ХҮЧИН ЧАДАЛ
60ТН
/ХОНОГТ/



БОРЛУУЛАЛТ,
ТҮГЭЭЛТИЙН ЦЭГ
3000
/ХОНОГТ/



СҮҮ, ТАРАГ БОЛОВСРУУЛАХ
ХҮЧИН ЧАДАЛ
150ТН
/ХОНОГТ/



ЗАЙРМАГ ҮЙЛВЭРЛЭЛИЙН
ХҮЧИН ЧАДАЛ
150ТН
/ХОНОГТ/

“Сүү” ХК нь 2023 оны хагас жилийн байдлаар нийт 565 ажилтантай байна.




Ажиллаж буй чиглэл



Боловсрол



Ажилчдын хүйсийн харьцаа



МАЛЧИД, ФЕРМЭРҮҮДЭД ЧИГЛЭСЭН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ӨНӨТЭЙ ӨВӨЛ 2023

100 сая төгрөгийн шагналын сантай “Өнөтэй өвөл 2023” сугалаат хөтөлбөр зохион байгуулав.

100 сая
төгрөг



ЗЭЭЛ ОЛГОВ

Хоршоодийн хаврын тариалалтанд зориулж нийт 700 сая төгрөг хүүгүй зээл олгов.

700 сая
төгрөг



ХИВЭГ ТЭЖЭЭЛ

2022 намраас 2023 хаврыг дамнан 1,3 сая тн хивэг тэжээлийг бэлтгэн нийлүүлэгчдэд үйлдвэрийн үнээр нь хүргэв.

1.3 сая ТОНН
хивэг эрдэс бодис, тэжээл



МАЛЧИД, ФЕРМЭРҮҮДЭД ЧИГЛЭСЭН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХОРШОО БАЙГУУЛАВ

Малчдын сүү бэлтгэлийн тогтолцоог хөгжүүлэх ажлын хүрээнд 4 хоршооны дэд бүтцийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн нийт хоршоодын тоог 14-т хүргэв.

14 хоршоо



СУРГАЛТАНД ХАМРУУЛАВ

Малын удмын сантай хамтран хоршоо бүрт зоотехникч бэлтгэх зорилготойгоор эхний ээлжийн бэлтгэн нийлүүлэгчдийг зоо техникч буюу зохиомол хээлтүүлгийн сургалтанд үнэ төлбөргүй хамруулж эхлэв.



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Хоршоодын бэлтгэн нийлүүлэгчдийг Өвөр Монголын Хөх хот, шилийн гол аймгийн малчидаас туршлага судлуулах, танилцах сургалтыг зохион байгуулан хамруулав.



МАКС АГРО ФЕРМ




431 га талбайд тариалалт хийв.

1500 га талбайд арчилгаа, хамгаалалт уринш хийв.

Компанийн эхний хагас жилийн онцлох үйл ажиллагаа

- Кристина Нобелийн Хүүхдийн Сангийн дэргэдэх Нархан асрамж халамжийн төвийн хүүхдүүдийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг хангах санамж бичгийг байгуулсан.
- “Сүү” ХК хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч байгууллагаар шалгарлаа.
- ISO 17025 стандартаар 10 дахь удаагаа амжилттай итгэмжлэгдлээ.
- Монгол Улсын онцлох аж ахуйн нэгжийг тодруулдаг “Entrepreneur 2022” шагнал гардуулах ёслолоор Сүү ХК нь “Оны шилдэг аж ахуйн нэгж”-ээр шалгарсан.
- Milk брендийн сүү тутмаас 8 төгрөгийг эмэгтэйчүүдийн санд хандивласан.
- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хүнсний хувьсгал, Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Сүү” ХК-ийн үйлдвэртэй танилцлаа.
- Сүүгээ ууя, Таргаа ууя хөтөлбөр амжилттай хэрэгжлээ.
- Сүү ХК “ТОП-100” Аж ахуйн нэгжээр шалгарав
- Сүү ХК нь Монголын шатрын холбоотой хамтран 40 сая төгрөгний шагналын сан бүхий өсвөрийн шатарчдын “NI-HIGH” тэмцээн амжилттай зохион байгуулж 630 гаруй тамирчид оролцлоо.
- Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Дэлхийн сүүний өдрийг тохиолдуулан “Сүү” ХК, М-Март сүлжээ дэлгүүр болон малчид, фермерүүд хамтран 10,000 бяцхан хүүхдэд сүүн зайрмаг бэлэглэлээ.



3 сая
хэрэглэгч

7000 Хувьцаа
ЭЗЭМШИГЧИД

Сүү ХК, 550
ажилтан



250 Түүхий
ЭД МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭГЧ

2500 Бэлтгэн
НИЙЛҮҮЛЭГЧ

4500
Харилцагч



Компанийн засаглал

“Сүү” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байдаг.

“Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөл нь нийт 12 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааг байнгын, тогтвортой, мэргэжлийн удирдлагаар хангаж, Компанийн тухай хууль, Төрийн холбогдох эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон компанийн дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооноос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн дагуу ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болоод баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТУЗ гишүүдийн багийг шинэчилж чадварлаг мэргэжилтнүүдийг томиллоо



Д. ГАНБААТАР
ТУЗ-ийн дарга



Д. ЦЭРЭНЖИГМЭД
ТУЗ-ийн гишүүн



Д. ТУНГАЛАГ
ТУЗ-ийн гишүүн



С. ОТГОНЖАРГАЛ
ТУЗ-ийн гишүүн



С. СҮХБОЛД
ТУЗ-ийн гишүүн



Д. УЯНГАЛЯНХУА
ТУЗ-ийн гишүүн



Д. ЖАМЪЯН
ТУЗ-ийн гишүүн



Б. ТҮВШИНТӨГС
ТУЗ-ийн гишүүн



Б. БАТЗОРИГ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Г. БАЯР
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Н. ЦЭРЭНДОРЖ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Д. ДАВААНЯМ
ТУЗ-ийн хараат
бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулав





Сүү ХК-ийн Гүйцэтгэх захирал
М. Болод



Маркетинг, Борлуулалт
хариуцсан дэд захирал Г. Пэлжидмаа



Үйлдвэрлэл хариуцсан
дэд захирал Д. Бямбажав

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



Санхүүгийн
албаны дарга
Ш. Даваалимбэ



Худалдан авалт,
хангамжийн
албаны дарга
Б. Ананд



Сүү бэлтгэлийн
албаны дарга
Б. Амарбаясгалан



Чанар, лабораторийн
албаны дарга
Ц. Батгэрэл



Технологийн
албаны дарга
С. Оюунбилэг



Авто баазын
ерөнхий инженер
Ц. Баасандорж



Техникийн
албаны дарга
Г. Бадамтуяа



Маркетингийн
албаны дарга
Т. Даваадорж



Улаанбаатар хот хариуцсан
борлуулалтын
албаны дарга
Б. Алтанхишиг



Хөдөө орон нутаг
хариуцсан борлуулалтын
албаны дарга
Б. Сүхбат



Захиргаа, Хүний нөөцийн
албаны дарга
Б. Ариунболд



Макс агро
фермийн дарга
З. Чулуунцэцэг



“Эрдэнэт” салбар
хариуцсан дарга
Д. Ариунсүвд

WWW.SUU.MN



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД



БАРИМТ БИЧИГ



**Та дээрхи заавраар
холбогдох мэдээллийг
авах боломжтой**

**Компанийн засаглалын
кодексийн холбогдох журмуудыг
эцэслэн батлав.**

- Компанийн тогтвортой хөгжлийн бодлого
- Компанийн ногдол ашгийн бодлого
- Компанийн залгамж халааны бодлого
- Компанийн цалин урамшууллын бодлого
- Компанийн дотоод аудитын заавар
- Компанийн дотоод хяналтын заавар
- Компанийн эрсдлийн удирдлагын заавар
- Компанийн комплайнсын хяналтын заавар
- Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр
- Компанийн эрх бүхий албан тушаалтны ёс зүйн дүрэм
- Компанийн мэдээллийн ил тод байдал тайлагналын журам
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зарчлийг зохицуулах журам
- ТУЗ-ийн оролцогч талын бодлого
- ТУЗ-ийн нэр дэвшүүлэх журам
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирлага, комплайнсын хорооны үйл ажиллагааны журам

WWW.SUU.MN



Код: 135	Бүртгэлтэй бирж: Монголын Хөрөнгийн Бирж	Бүртгэгдсэн огноо: 1992 он	Бизнес: Хүнсний үйлдвэрлэл
Хувьцааны төрөл: Энгийн	Бүртгэлийн ангилал: ангилал	ISIN: MN00APU00900	Хувьцааны симбол: SUU

Хувьцааны мэдээлэл

Ногдол ашигийн
мэдээлэл

Хувьцаа
эзэмшигчдийн бүтэц

Хувьцааны өгөөжийн
тооцоолол хийх

Хувьцаа худалдан
авах заавар

ТОВЧИН ДЭЭР ДАРЖ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ.

Та дараах заавраар дор дурдсан
мэдээллийг авах боломжтой



ХУВЬЦАА
НОГДОЛ АШИГ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ
ХУВЬЦААНЫ ӨГӨӨЖИЙН ТООЦООЛОЛ
ХЭРХЭН ХУВЬЦАА ХУДАЛДАЖ АВАХ ВЭ?



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

СҮҮ Хувьцаат Компани

**АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТАНД
БАЯРЛАЛАА**